



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 1/2017

Мандалговь

Г Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтаар заасныг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн төвийн Малчин хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах, дэд өртөө барих ажил /ДУОНӨГ/2017/00002/ ажлыг ашиглалтад оруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ж.Мөнхчулуун /Аймгийн Засаг даргын орлогч/

Нарийн бичгийн дарга: Н.Эрдэнэ-Очир /Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн дарга/

Гишүүд:

Д.Наргуй /ГХБХБГ-ын БХБХэлтсийн дарга/

Б.Золжаргал /МХГ-ын Эрчим хүч, мэдээлэл холбооны хяналтын улсын байцаагч/

Я.Алтанхундага /Аймгийн ОБГ-ын дарга/

О.Мөнхсайхан /"Мон-Энержи Консалт" ХХК-ний инженер/

О.Мөнхзул /Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХэлтсийн Барилга, хот байгуулалт, дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн/

Б.Адъяасүрэн /Аймгийн ОНӨГ-ын ахлах мэргэжилтэн/

М.Мэнгэнгэрэл /"Мон-Энержи Корпораци" ХХК-ний инженер/

С.Очибат /"БЗӨБ ЦТСС"-н харьяа Дундговь ЦТССалбарын ерөнхий инженер/

П.Алтанжимсэг /Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дарга/

Хоёр. Засвар шилжилтийн ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, засварын ажлыг зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлтийг гарган, архивд хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс /Ж.Мөнхчулуун/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ



0200021